

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР 2017 ОНД  
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

/2017 оны жилийн эцсийн байдлаар/

2017.12.13

**Нэг. Танилцуулга**

ЗТХЯ нь 2017 онд Засгийн газрын хуралдаанаар нийт 27 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, саналаа ЗГХЭГ-т хүргүүлэн зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.01.23-ны өдрийн 14 дүгээр тушаалаар батлуулсан байна.

2017 оны төлөвлөгөөнд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгагдсан асуудлын тоог газар, хэлтсээр нь авч үзвэл (давхардсан тоогоор):

№	Хариуцах газар, хэлтэс	Улирал				Нийт	
		I	II	III	IV	нийт	Үүнээс толгойлон
1	БТГ	4	13	5	5	27	4
2	ТЗУГ	-	4	1	-	5	-
3	ТЗДТБХЗГ	2	2	3	-	7	6
4	АТБХЗГ	1	3	-	2	6	4
5	АЗБХЗГ	-	2	-	-	2	2
6	АТБХЗХ	-	7	2	3	12	11
<b>Нийт</b>		<b>4</b>	<b>13</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>27</b>	

Засгийн газрын хуралдаанаар 2017 онд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 27 асуудлын хэрэгжилтийн байдал:

№	Газрын нэр	Төлөвлөсөн	Боломжгүй болсон	Хэрэгжилтийн явц				Хувь
				100%	70%	30%	0%	
1	БТГ	27	3	11	5	8	-	70,4
2	ТЗУГ	5	-	-	3	2	-	54,0
3	ТЗДТБХЗГ	7	1	3	-	3	-	65,0
4	АТБХЗГ	6	1	1	2	2	-	60,0
5	АЗБХЗГ	2	-	2	-	-	-	100,0
6	АТБХЗХ	12	1	5	3	3	-	72,7
<b>Нийт</b>		<b>27</b>	<b>3</b>	<b>11</b>	<b>5</b>	<b>8</b>	<b>-</b>	<b>70,4</b>

## Хоёр. Үнэлэлт, дүгнэлт

### 1. Төлөвлөлтийн байдал:

1) 2016 оны төлөвлөгөөнд тусгаад хэлэлцүүлээгүй үлдсэн 22 асуудлаас 2017 оны төлөвлөгөөнд 16 асуудлыг тусгаж, 6 асуудлыг тусгаагүй хассан бөгөөд эдгээр нь төлөвлөгөөнд тусгах шаардлагагүй асуудлууд байна.

2) 2016 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу 2017 онд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг тухайн оны 1 дүгээр сард багтаан 2017.01.23-ны өдрийн Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар батлуулсан байна.

### 2. Хэрэгжилтийн байдал:

1) 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 27 асуудлаас 9 асуудлыг хэлэлцүүлсэн, 2 асуудал хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн, 1 асуудлыг хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч шаардлагагүй гэж буцсан, 2 асуудлыг хэлэлцүүлэх боломжгүй болсон, 70%-ийн хэрэгжилттэй 5, 30%-ийн хэрэгжилттэй 8 асуудал, төлөвлөгөөний хэрэгжилт **70.4%**-тай байна.

2) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлгүй тээвэрлэгчээс төлбөр хураах журам”-ын төслийг ЗГХЭГ-аас Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн “Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч нь заавал хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгсэлтэй байх” гэсэн үзэл баримтлалтай зөрчилдөхөөр байгаа тул урт хугацаанд байнга хэрэгжихээргүй, улсын эдийн засаг, нийгэмд ач холбогдол багатай эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт батлахаас татгалзах нь зүйтэй гэсэн үндэслэлээр буцаасан байна.

3) ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсантай холбогдуулан орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувиар тогтоолгох асуудлыг хойшлуулсан. Мөн хөлөг онгоц бүртгэх журмын шинэчилсэн найруулгын төслийг Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулсны дараа тус хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлуулсан байна.

4) Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичиг”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төсөл, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д өөрчлөлт оруулах тогтоолын төсөл, “Авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн төсөл, “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”, “Агаарын тээврийг хялбаршуулах хөтөлбөр”-т нэмэлт өөрчлөлт оруулах, “Аюултай ачаа тээвэрлэх тухай Европын хэлэлцээр”-т нэгдэх орох тогтоолын төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажил удаашралтай буюу 30%-ийн хэрэгжилттэй байна.

## Гурав. Санал, зөвлөмж

1) Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг яамны бусад төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжих боломжтой хугацаанд, хэлэлцүүлэх шаардлагатай асуудлыг бүрэн хамруулж төлөвлөж байх;



2) 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан боловч хэрэгжээгүй ажлуудыг 2018 оны Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулах, оны эхний хагаст багтаан хэрэгжүүлэх талаар газар, хэлтсийн дарга нар онцгой анхаарч ажиллах,

3) Зам, тээврийн салбарын 4 хуулийн төсөл, Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд болон Иргэний нисэхийн салбарын 2 үндэсний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг түргэтгэх;

4) Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг газар, хэлтсийн дарга нар тухайн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн Үр дүнгийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийн нэг болгож ажиллах;

Танилцсан:

Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Махбал

Бодлого төлөвлөлтийн газрын дарга Р.Мэргэн

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржханд

Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Батболд

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Артур

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга С.Мөнхнасан

Хянасан:

ХШҮДАГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Баярмаа